

“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын
04-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт 13”



**“БЭРС ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН
ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Бэрс финанс ББСБ” ХХК (цаашид “компани” гэх)-ийн ТУЗ-ийн гишүүд болон бүх ажилтнуудын баримтлах ёс зүйн зарчим, дүрмийг тогтооход оршино.

Хоёр. ТУЗ-ийн гишүүдийн баримтлах ёс зүйн зарчим

- 2.1 Монгол улсын хууль тогтоомж, компанийн дотоод дүрэм журам, “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д заасан өөрийн үүргээ нэр төртэй биелүүлэн ажиллах;
- 2.2 ТУЗ-ийн гишүүний хувьд аливаа асуудлаар шийдвэр гаргахдаа компанитай болон харилцагчид, бусад оролцогч талуудтай сонирхлын зөрчил үүсгэхээс сэргийлж, үүссэн тохиолдолд зохих журмын дагуу ТУЗ-ийн дарга болон холбогдох бусад этгээдэд мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцдоггүй байх журмыг чанд баримтлан ажиллах;
- 2.3 Шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцоходоо бусдын нөлөөнд авталгүй хараат бусаар ажиллах;
- 2.4 Мэргэжлийн мэдлэг, ялангуяа компанийн сайн засаглалын зарчмын талаар мэдлэг, тэдгээрийг практикт нэвтрүүлэх талаар ур чадвараа цаг ямагт дээшлүүлэх, шударга ажиллах;

Гурав. Ажилтнуудын баримтлах ёс зүйн зарчим

- 3.1 Компанийн ТУЗ-ийн гишүүдээс эхлээд бүх түвшний ажилтнууд нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг тасралтгүй мөрдөн ажиллана. Үүнд:
- 3.1.1 Мэргэжлийн ёс зүйтэй байх;
- 3.1.2 Монгол улсын хууль тогтоомж, компанийн дотоод дүрэм журам, түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасан өөрийн үүргээ нэр төртэй биелүүлэн ажиллах;
- 3.1.3 Өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулахдаа компани болон харилцагчид, бусад оролцогч талуудтай сонирхлын зөрчил үүсгэхээс сэргийлж, үүссэн тохиолдолд зохих журмын дагуу холбогдох этгээдэд мэдэгддэг байх журмыг чанд баримтлан ажиллах;
- 3.1.4 Үйл ажиллагаа явуулахдаа харилцагч, зээлдэгчийн эрх ашгийг тэргүүн ээлжид тавих зарчмыг ямагт мөрдөн ажиллах;
- 3.1.5 Үйл ажиллагаа явуулахдаа бусдын нөлөөнд авталгүй хараат бусаар ажиллах;

- 3.1.6 Мэргэжлийн ур чадвараа цаг ямагт дээшлүүлэх, шударга ажиллах;
- 3.1.7 Харилцагч, зээлдэгчдийг үнэн зөв мэдээллээр бүрэн хангахыг ямагт чармайн ажиллах.

Дорov. Ажилтнуудын ёс зүйн дүрэм

- 4.1 Ажилтнууд нь үйл ажиллагаандаа дор дурьдсан ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.
Үүнд:
 - 4.1.1 Эрх бүхий байгууллагаас баталсан болон компанийн дотоодод баримтлах ёс зүйн дүрмийг сайтар судлан, дагаж мөрдөн ажиллах үүрэг хүлээх бөгөөд энэ тухайгаа бичгээр баталгаа гаргаж өгнө.
 - 4.1.2 Ажил үүргийнхээ дагуу харилцагч, зээлдэгчээс авсан мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг чанд хадгалан зөвхөн ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиглана.
 - 4.1.3 Энэхүү дүрмийн 3.1.2 дах заалт нь хууль журмаар хүлээсэн үүргийнхээ дагуу харилцагч, зээлдэгчийн хууль бус үйлдлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх үүрэг, шүгэл үлээх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хууль тогтоомжийн дагуу мэдээлэл өгөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
 - 4.1.4 Ажилтан нь өөрийн компанийн болон харилцагч, зээлдэгчийн үйл ажиллагаатай холбоотой олон нийтийн хүртээл болоогүй байгаа дотоод мэдээлэл ашиглан гүйлгээ хийх, бусдад дамжуулах зэрэг үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.
 - 4.1.5 Ажилтан нь аливаа үйл ажиллагаа явуулахдаа бүх харилцагчиддаа ижил тэгш хандах зарчмыг чанд баримтлан ажиллана.
 - 4.1.6 Харилцагч, зээлдэгчийн ашиг сонирхлыг өөрийн хувийн ашиг сонирхлоос тэргүүнд тавих зарчмыг баримтлан ажиллана.
 - 4.1.7 Ажилтан өөрийн болон компанийн нэрийн өмнөөс гүйлгээ хийхдээ харилцагч, зээлдэгчийн ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй гүйлгээ хийхийг хориглоно.
 - 4.1.8 Өөрийн бие даасан хараат бус, шударга байдалд нөлөөлж болох бизнесийн харилцаанд оролцох, бэлэг шагнал төлбөр, түүнтэй адилтгах зүйлсийг аливаа иргэн хуулийн этгээдээс авахыг хориглоно.

Тав. Ажилтан үндсэн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ баримтлах зарчим

- 5.1 Салбарын ажилтан нь зээл олгох шийдвэр гаргах үндэслэл болсон мэдээллийг бэлдэхдээ мэргэжлийн өндөр ур чадвар гарган, нухацтай хандаж, холбогдох хууль, байгууллагын журам, арга аргачлалыг дагаж мөрдөнө.
- 5.2 Зээл олгох шийдвэр гаргахдаа эрсдэлийг зөв үнэлэн, бие даасан, хараат бусаар шийдвэр гаргана.

Зургаа. Хариуцлага

- 6.1 Компанийн ажилтны энэхүү дүрмийг зөрчсөн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлага хүлээлгэнэ.